



2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр



ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна. Үүнд:

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэж заасан.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6-д төсвийн удирдлагыг хэрэгжүүлэхэд “төсвийн хөрөнгийн хуваарилалт, байршуулалт, хэрэглээ нь эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой байх” зарчмыг баримтална гэж; Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх” гэж заасан бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх” зарчмыг баримтална гэж 5.1.3-т тусгасан ба уг зарчмыг 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах байдлаар хэрэгжүүлнэ” гэж; Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд хөгжлийн бодлого, төлөвлөлтөд баримтлах зарчмуудыг 5 дугаар зүйлийн 5.1.4-т “тогтвортой, тасралтгүй, залгамж чанартай байх”, 5.1.8-д “судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх”, 5.1.11-д “төлөвлөлт нь үр дүнд чиглэсэн байх”, болон 5.1.13-т “бүх талын оролцоог хангасан байх” гэж тус тус хуульчилсан байна.

Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд төсвийн хөрөнгө оруулалтад хамаарах зорилтуудыг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

1.Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “АЛСЫН ХАРАА-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “Эдийн засаг” хэсгийн зорилт 4.1-ийн хүрээнд хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-ын 2-т “Төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төсөв, санхүүгийн тогтолцоотой болсон байна” гэж, түүнчлэн, урт хугацааны хөгжлийн

санхүүгийн тогтолцоотой болсон байна” гэж, түүнчлэн, урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.1.6-д “Улсын төсвийн сахилга бат, санхүү, мөнгө, зээлийн бодлого, зохицуулалтын удирдлагыг сайжруулна” гэж, 4.1.21-д “Төсөв, мөнгө, зээл, гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын харилцан уялдаатай бодлого хэрэгжүүлж, эдийн засгийн өсөлт болон бүтцийн өөрчлөлтийн ололтыг цаашид тогтвортой хадгална” гэж, 5.2.11-д “Улсын нэгдсэн төсвийг урт хугацааны хөгжлийн бодлого болон Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тулгуурлан боловсруулж, батлах тогтолцоог бүрдүүлж бэхжүүлнэ” гэж;

2. Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын 3 дахь хэсгийн Бүсүүдийн хөгжлийн нийтлэг зорилгод “-Улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаад зээл, тусламж, орон нутгийн төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрийг оновчтой хуваарилна;” гэж, 5 дахь хэсгийн 5.2-т “Бүс нутгийн тэргүүлэх чиглэл, байгаль газар зүйн нөхцөл, нөөц, байршлын давуу талтай уялдсан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд улсын төсвийн хөрөнгө оруулалт, гадаад зээл, тусламж, орон нутгийн төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрийг оновчтой хуваарилна” гэж;

3. Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.2.2-т “Эдийн засгийн нийт нөөц, улирлын онцлогтой нийцүүлэн төсвийн хөрөнгө оруулалтын эрэмбэ, дарааллыг оновчилж, нийгэм, эдийн засгийн салбарт оролцох хүрээ, хязгаарыг хуулиар тогтоож, ... хиймэл оюун ухааныг ашиглана” гэж, 3.2.2.14-т “Төсвийн хөрөнгө оруулалтыг их өгөгдөлд суурилан төлөвлөнө” гэж тус тус заасан байна.

Монгол улсын хэмжээнд төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын асуудлыг зохицуулсан бие даасан хууль байхгүй бөгөөд суурь харилцааг Төсвийн тухай хуулиар голчлон зохицуулж, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулж байна.

Төслийн төлөвлөлт, төслийн хэрэгжилт, санхүүжилт, гүйцэтгэл, хяналт, тайлагналттай холбоотой зарчмын шинжтэй чухал асуудлууд Засгийн газар, Сангийн сайдын баталсан журам, аргачлалуудаар зохицуулагдаж буй нь төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын бодлого, зохицуулалт нэгдмэл бус, хууль, эрх зүйн орчин хангалтгүй байгааг илтгэж байна. Өнгөрсөн хугацаанд төсвийн хөрөнгө оруулалтыг үр ашигтай болгох, эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор Төсвийн тухай хуулийн төсвийн хөрөнгө оруулалтад хамаарах зүйл, хэсэг, заалтад давхардсан тоогоор 44 удаа нэмэлт, өөрчлөлтийг оруулсан байна.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16¹.5.4-т¹ заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай багц хуулийн төсөлд өгсөн дүгнэлтдээ “Хөрөнгө оруулалтын

¹ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, 16¹.5.4. Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос өгсөн чиглэлийн дагуу төсөвтэй холбоотой хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийн улсын төсөвт нөлөөлөл, ачаалал үзүүлэх эсэх талаар шинжилгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргаж танилцуулах;

төслийг сонгох, эрэмбэлэх, хууль эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай” гэж, “Хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц хууль эрх зүйн орчин хэрэгтэй” гэж онцлон тэмдэглэсэн бөгөөд энэ хүрээнд “... хөрөнгө оруулалтын тухай хуулийг шинээр боловсруулан гаргах шаардлагатай” гэж, мөн “Төсвийн хөрөнгө оруулалтыг сонгох, эрэмбэлэх, үр ашгийг тооцоход журмын зохицуулалт хангалтгүй бөгөөд хөрөнгө оруулалтын эрх зүйн цогц орчин бий болгохын тулд бусад орнуудын сайн туршлагын дагуу Төсвийн хөрөнгө оруулалтын тухай хуулийг шинээр боловсруулах шаардлагатай” болохыг чухалчлан зөвлөсөн.

“Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Ерөнхий сайдын 2025 оны 02 тоот албан даалгаврын 3.5-д “Төсвийн хөрөнгө оруулалт, томоохон төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийг шийдвэрлэх чиглэлээр хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох хуулийн төсөл боловсруулж, Улсын их хуралд өргөн мэдүүлэхийг” даалгасан байна.

Иймд, дээр дурдсан төсвийн хууль тогтоомж дахь зарчмуудыг хэрэгжүүлэх, бодлогын баримт бичгүүдэд тусгасан зорилтуудыг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, зохицуулалтыг нэгдмэл удирдлагаар хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

1.2.Практик шаардлага

Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын түүхэн замнал нь анхны Сангийн яам буюу Сангийн хамаг хэргийг бүгд захиран шийтгэгч яам байгуулагдсан цаг үеэс эхлэлтэй бөгөөд 110 гаруй жилийн түүхтэй. Монгол Улсын хувьд төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг улсын төсөв, гадаадын зээл, тусламж, орон нутгийн төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэл, орон нутгийн хөгжлийн сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө, хөгжлийн сан болон санхүүгийн бусад эх үүсвэрүүд бүрдүүлдэг.

Төсвийн хөрөнгө оруулалтаар авто зам, эрчим хүч, инженерийн дэд бүтэц зэрэг нийтийн зориулалттай дэд бүтцийн бүтээн байгуулалтууд, мөн сургууль, цэцэрлэг, эмнэлэг, дотуур байр, музей, соёлын төв, захиргааны байр зэрэг төрийн үйлчилгээний барилга байгууламжуудыг барьж байгуулах төслийг хэрэгжүүлсэн бөгөөд энэ нь иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлж, төрийн үйлчилгээг цаг алдалгүй иргэдэд хүргэхээс гадна эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэсээр ирсэн. Монгол Улсад 2016-2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 16.5 их наяд, гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр 12.4 их наяд, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр 11.1 их наяд төгрөг буюу нийт 39.9 их наяд төгрөгийн эх үүсвэр тус тус хөрөнгө оруулалтаар батлагдаж, хэрэгжсэн байна.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд өгсөн дүгнэлтдээ “Хөрөнгө оруулалтыг үнэлж эрэмбэлэх, сонгох үйл ажиллагаа нь Засгийн газар, Сангийн яамны баталсан журмын хүрээнд хэрэгжиж байгаа бөгөөд энэ нь сул талтай байна. Хөрөнгө оруулалтын төслийг төлөвлөхөөс эхлээд сонгох хүртэлх үйл явц нь Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яам, Төсвийн ерөнхийлөн захирагчийн оролцоотой хийгддэг боловч үүнд ил тод байдал, олон нийтийн оролцоо, хөндлөнгийн хяналт дутагдаж байна. Мөн төсвийн төсөлд хөрөнгө оруулалтын төслийг тусгахдаа холбогдох дүрэм, журмыг баримталдаг эсэх нь тодорхойгүйгээс гадна хөгжлийн бодлого, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт

тусгагдаагүй, зураг төсөл, техник эдийн засгийн үндэслэл нь гараагүй, санхүүжилтийн эх үүсвэр нь тодорхойгүй төслийг улсын төсөвт тусгах асуудал байгаа нь төсвийн хөрөнгө оруулалтын үр ашигт сөргөөр нөлөөлөх магадлалтай. Иймд хөрөнгө оруулалтыг төлөвлөх, үнэлж эрэмбэлэх, сонгох одоогийн хууль, дүрэм журмыг сайжруулах шаардлагатай” болохыг тусгайлан дурдсан.

Сангийн яам нь 2018 оноос хойш төсвийн хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйн орчныг сайжруулах зорилгын хүрээнд Төсвийн тухай хуульд 2022 онд улсын хөрөнгө оруулалтын урьдчилсан үнэлгээ болон төлөвлөлт, хөрөнгө оруулалтын төсөвлөлтийн талаар шинэчилсэн зохицуулалтыг тусгаж, төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлагыг нэмэгдүүлсэн. Түүнчлэн, Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх, үйл ажиллагааны журам болон холбогдох аргачлалууд”, Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”, Сангийн сайдын 2023 оны 137 дугаар тушаалаар “Улсын хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэх оновчтой эх үүсвэрийг тодорхойлох урьдчилсан үнэлгээний аргачлал” болон Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ыг тус тус шинээр болон шинэчлэн баталж, мөрдүүлсэн.

Улсын Их Хурлын даргын 2024 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” 75 дугаар захирамжаар нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, захиргааны хэм хэмжээний актын тоог цөөрүүлэх, цэгцлэх талаар санал дүгнэлт гарган холбогдох хууль тогтоомжийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Тодруулбал, нийгмийн чухал асуудлыг журмаар бус хуулиар зохицуулах бодлого баримталж байна. Энэ хүрээнд төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын харилцааг зохицуулж байгаа дээрх журам, захиргааны хэм хэмжээний актыг цэгцэлж, журмаар бус Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулиар зохицуулах зайлшгүй шаардлагатай болсон.

Сүүлийн жилүүдэд төсвийн хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж, хөгжлийн бодлого, хамрах хүрээ өргөжихийн хэрээр төслүүдийн хэрэгжилтэд тулгамдаж буй зарим асуудлаас үүдэн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, удирдлага, зохицуулалтын хууль, эрх зүйн орчныг илүү боловсронгуй болгож, сайжруулах зайлшгүй шаардлага тулгамдаж байна.

Дэлхийн банк, Олон Улсын Валютын Сан (ОУВС)-тай хамтран төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлоор эрэмбэлэх аргачлалыг 2019 оноос, төсвийн хөрөнгө оруулалтын цахим системийг 2020 оноос эхлэн хөгжүүлж, үйл ажиллагаанд нэвтрүүлэн ашиглаж байгаа боловч төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийг нэн тэргүүний хэрэгцээ шаардлага, ач холбогдол, эдийн засгийн үр ашгаар нь эрэмбэлэх, төслийн бэлтгэл ажил болон техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ), зураг төслийг бүрэн бэлтгэж, газрын асуудлыг шийдвэрлэсний дараа төсөвт тусгах зэрэг асуудал практикт хангалтгүй хэрэгжиж байна.

Нөгөө талдаа төслийг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааг зохих журмын дагуу гүйцэтгэж, хөрөнгө оруулалтын төслүүдийг төсөвт тусгахаар Засгийн газар, УИХ-д хүргүүлсний дараа үнэлгээ хийгдээгүй, эрэмбэлээгүй, бэлтгэл ажил бүрэн

хангагдаагүй төслүүд нэмэгдэн батлагдаж буйн улмаас төслүүд удаашрах, нэмэлт санхүүжилт шаардах, төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг сулруулах зэрэг эрсдэл гарсаар байна.

Тандан судалгаагаар төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд тулгарч байгаа гол асуудал нь төслийн хэрэгжилт удаан, өртөг нэмэгдэж, төсөвт ачаалал үүсгэдэг, эдийн засгийн үр ашиг, өгөөж хангалттай бус, Монгол Улсын хөгжлийн бодлогод тусгасан зорилго, зорилтыг бүрэн дүүрэн хангаж чадахгүй байгаа нь тогтоогдсон. Төслийн хэрэгжилтийн сайжруулалт, тохируулга, зураг төсөл, ТЭЗҮ-гийн талаар нэгдсэн стандарт байхгүй, эрсдэлийн, хүний эрхийн болон уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хөндлөнгийн үнэлгээ байхгүй, хяналтын нэгдсэн тогтолцоо сул, гэрээний хэрэгжилт, мэдээллийн ил тод, нээлттэй байдал, олон нийтийн оролцоо, хариуцлагын талаарх зохицуулалт хангалтгүй байгаа тул төсвийн хөрөнгө оруулалтын бүх үе шатанд дагаж мөрдөх нэгдсэн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх нь зүйтэй.

Төслийн төсөвт өртөг, онцлог шинж, цар хүрээ, эдийн засгийн үр ашиг, өгөөж, эрсдэл зэргийг шалгуур үзүүлэлт болгодог төслийн олон улсын ангилал нь манай улсын хувьд улсын болон орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төсөлд байдаггүй, төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн зориулалт, зарцуулалтыг ангилж зохицуулаагүй тул улсын төсвөөр их, бага дүнтэй төслүүдэд нэг ижил түвшний зохицуулалт үйлчилж байна. Тодруулбал, 2016-2024 оны хооронд улсын төсвийн хөрөнгө оруулалтад хамгийн багадаа 8.3 сая төгрөг, хамгийн ихдээ 676.3 тэрбум төгрөг хүртэлх өртөг бүхий төслүүд батлагдсан байна. Угтаа бол улс, орон нутгийн төсвөөс, тусгай сангуудаас ямар цар хүрээтэй, ямар шалгуур хангасан төслийг санхүүжүүлэх талаарх хүрээ хязгаарыг хуулиар төслийн ангиллын дагуу тодорхойлж, тогтоох шаардлагатай юм.

Хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн зориулалт тодорхой бус, төслийн ангилал, төрөл байхгүй, төслийн бэлтгэл ажилтай холбоотой нэгдсэн ойлголт, удирдлага, зохицуулалт хангалтгүй байдгаас үүдэн жил бүрийн төсвийн төсөлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр ирүүлсэн нийт төслийн саналын дунджаар 15-20 хувь нь төсөвт тусгагдаж, дийлэнх буюу 80-85 хувь нь шийдвэрлэгдэхгүй үлдэж байна. Төслийн хэмжээ болон салбарын онцлогтой уялдуулан эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тогтоох, түүнд үндэслэн үнэлгээний шалгуур үзүүлэлтээр эрэмбэлэх үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлдэг эрх зүйн орчныг журмаар бус хуульд бий болгож, хэрэгцээ, шаардлагагүй, үр ашиггүй төсөл хэрэгжих буюу нэмэлт санхүүжилт гарахаас урьдчилан сэргийлсэн зохицуулалтыг бий болгох нь зүйтэй байна.

Практикт төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх гурван төсөл тутмын нэгд нь нэмэлт санхүүжилт үүсэж, нэг нь төлөвлөсөн хугацаанаас нэгээс дээш жилээр хойшилж ашиглалтад орж байна. Тухайлбал, зөвхөн сүүлийн 2 жил буюу 2023 онд барилгын материалын үнийн өсөлтөд 303.4 тэрбум төгрөг, 2024 онд аудитын дүгнэлтээр 660.6 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилт олгосон байдаг. Улмаар төсөвт нэмэлт ачаалал үүсгэж, барилга байгууламж, дэд бүтэц хугацаандаа ашиглалтад ороогүйн улмаас боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн үйлчилгээний хүртээмж саарч, төсвийн хөрөнгө оруулалтын өгөөж буурах сөрөг үр дагаварт хүргэж байна.

Дэлхийн банкнаас 1)хөрөнгө оруулалтын стратеги, бодлого; 2)төслийн албан ёсны үнэлгээ; 3)төслийн хөндлөнгийн үнэлгээ; 4)төслийн сонголт ба төлөвлөлт; 5)төслийн хэрэгжилт; 6)явцын тохируулга, сайжруулалт; 7)хөрөнгийн удирдлага болон 8)төслийн хяналт, тайлагналт гэсэн төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагад заавал байх 8 үе шатыг тодорхойлсон байдаг. Энэ нь төсвийн хөрөнгө оруулалтын төслийг амжилттай, үр дүнтэй хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулсан, дэлхийн бусад улс орнуудад нэгэнт тогтсон тогтолцоо бөгөөд манай улсын хувьд эдгээр процессын бүх үе шатыг хамруулан хууль зүйн хувьд нэг бие даасан хуулиар тодорхой зохицуулах шаардлагатай байна.

ОУВС-гийн “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын үнэлгээний шинэчлэл” тайланд “1/төсөлд үнэлгээ өгөх, ач холбогдлоор нь эрэмбэлэх, сонгон шалгаруулах зохицуулалтыг боловсронгуй болгох замаар төслийн үнэлгээ, сонгон шалгаруулалтыг бэхжүүлэх, ... мега төсөл, хөрөнгийн төрөл, санхүүжилтийн эх үүсвэрийн дүн шинжилгээнд төслийн бүх зардал, эрсдэлийг тусгах, үнэлгээний нэмэлт шаардлага, сонгон шалгаруулалтын шалгуур боловсруулах; 2/төслийн хяналт, шалгалт, гүйцэтгэлийн үнэлгээ, төслийн тохируулга, дахин хуваарилалт зэрэг зохицуулалтыг тусгах, төслийн удаашрал, зардлын хэтрэлтийг хязгаарлах” шаардлагатай болохыг зөвлөсөн.

Түүнчлэн, Дэлхийн банкны “Монгол Улсын төрийн санхүүгийн үнэлгээ” судалгаанд “Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслийн сонголт хийх төлөвлөлт, арга зүйг сайжруулах, төслийн зураг төсөл, гүйцэтгэл цаг хугацаандаа хэрэгжихгүй удаашрах, худалдан авах ажиллагаанд авлига үүсэх, хөрөнгийг үр дүнтэй ашиглаж, арчлах зэрэг хөрөнгийн удирдлагыг оновчтой хийж чаддаггүйгээс барилга байгууламжийн ашиглалтаас хүртэх өгөөж, ашиглалтын хугацаа нь буурдаг, санхүүжилтийн эх үүсвэрийг хөрөнгө оруулалтаар нь ангилан эрэмбэлэх тогтолцоо байхгүй, төслийн сонгон шалгаруулалт, төлөвлөлтийг муу хийснээр хэрэгжилтэд хүндрэл үүсдэг” болохыг дурдсан байна.

Үндэсний аудитын газрын 2021-2024 оны төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, гүйцэтгэлийн тайлан, зөвлөмжид “Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг үргэлжлэх хугацаатай нь уялдуулахгүйгээр 3 жилд тэнцүү хуваарилахаар хуульд заасан нь олон жил үргэлжлэх томоохон барилга байгууламжийн хувьд төсөвт өртгийн хэмжээнээс хамаарч тухайн жилд төлөвлөсөн санхүүжилтийн эх үүсвэрийг бүрэн ашиглаж чадахгүй байх, нөгөө талаас санхүүжилт шаардлагатай бусад арга хэмжээний төсөв батлагдахгүй орхигдох эрсдэлийг үүсгэж байна” гэж, “Төсвийн төсөлд тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ бүрийг журмын дагуу үнэлж эрэмбэлэн, үргэлжлэх хугацааг үндэслэлтэй төлөвлөх шаардлагатай” гэж, мөн “ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаварт тавигдах шаардлага, хүлээн авах шалгуур, төсөвт өртгийг тооцох, хянах жишиг үнийг тогтоох, холбогдох зохицуулалтыг бий болгох шаардлагатай” болохыг тус тус дурдсан тул энэ талаарх зохицуулалтыг бий болгох шаардлага үүссэн.

Дээр дурдсанаас гадна төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд дараах практик шаардлагууд тулгамдаж байна. Үүнд:

Төсвийн хөрөнгө оруулалтын бүх эх үүсвэрийг хамруулсан санхүүжилтийн оновчтой хуваарилалт, зориулалт, хамрах хүрээг тогтоогоогүйн улмаас хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашгийг бууруулах, хөгжлийн бодлогын баримт бичигт туссан зорилго, зорилт бүрэн хангагдахгүй байх, хувийн хэвшил, орон нутаг, Засгийн

газрын хэрэгжүүлэх төслүүд давхардах зэрэг асуудал, зөрчлүүд гарч байна;

Хөрөнгө оруулалтын төслийн бэлтгэл ажил буюу зураг төсөл, ТЭЗҮ зэрэг ойлголтууд зохицуулалтын хувьд бүрхэг, тодорхой бус учир бүх төсөлд ижил шаардлага тавигддаг, мөн төлөвлөж хэрэгжүүлэхэд төслийн хугацаа болон зардал нэмэгдэхэд нөлөөлж байна;

Төслийн төсөвт өртөг буюу нийт хөрөнгө оруулалтыг бодитой тодорхойлдоггүй, төслийн онцлогт тохирсон ангилал, төрөл байхгүй тул төлөвлөлт оновчгүй болж хэрэгжилт удааширч улмаар төслийн менежментийн зардал нэмэгдэх, төслийн хэрэгжилтэд ойлгомжгүй, тодорхойгүй байдал үүсдэг;

Орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны ил тод байдалд тавих хяналт хангалтгүй, гарсан зөрчилд хариуцлага хүлээлгэдэггүй, мөн тус сангийн төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд иргэд олон нийтийн оролцоог бүрэн хангахгүй, төсөвт өртгийг хэт жижиглэснээр тендер оролцогчгүй болох, ажил он дамжих, хугацаа алдах, удирдлагын мэдээллийн системд төсөл, арга хэмжээний мэдээллийг дутуу болон огт оруулаагүй байхад сангаас санхүүжилт олгох зэрэг зөрчлүүд гарсаар байна;

Барилга, эрчим хүч, авто зам зэрэг салбарын норм, нормативын санд төсвийн хөрөнгө оруулалтын зардлаас ижил хувь хэмжээгээр хөрөнгө төвлөрүүлдэг хэдий ч норм нормативын баримт бичгийг шинэчлэх ажил хангалтгүй, сангийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулдаг, хариуцлагын тогтолцоо сул болох нь холбогдох хяналт, шалгалтаар тогтоогдсон. Төсвийн хөрөнгө ийнхүү үр ашиггүй зарцуулагдаж буйг өөрчилж, норм, нормативын сангийн удирдлага, менежментийг шинэчлэх шаардлагатай байна;

Төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд оролцогч байгууллагын хариуцлага, хяналтын талаарх зохицуулалт хангалтгүйн улмаас өмчийн удирдлага сулрах, ашиглалтын үр өгөөжийг тооцохгүй байх, түүнчлэн чанаргүй барилга байгууламж баригдах зөрчлүүд их гарч байна;

Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн ашиглалтын зардлыг бууруулах, үр өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд эрчим хүчний хэмнэлттэй, ногоон технологийг нэвтрүүлэх шаардлагатай байна;

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын зарим харилцааг хуулиар, зарим харилцааг журмаар зохицуулдаг бөгөөд зарим асуудлууд огт зохицуулалтгүй буюу хууль зүйн хийдэл үүссэн. Тухайлбал:

1. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төслийг бэлтгэх асуудлыг Төсвийн тухай хуульд тусгасан хэдий ч бусад хөрөнгө оруулалтын төслүүдийн талаар хуульд тодорхой тусгаагүй;

2. Мега төсөл, ногоон хөрөнгө оруулалт, их өгөгдөлд суурилан төлөвлөлтийг хийх талаарх зохицуулалт байхгүй;

3. Төсөлд тохируулга хийх болон төсөлд (бие даасан) хяналт тавих, төслийн үнэлгээ хийхтэй холбоотой харилцааг хуулиар зохицуулаагүй;

4.Төсөл хэрэгжүүлэх, төслийн тогтвортой үйл ажиллагааг хангахтай холбогдсон харилцааг хуульд тодорхой авч үзээгүй гэх мэт.

Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бүрдүүлдэг гадаадын зээл, тусламж, орон нутгийн хөгжлийн сангийн бодлого, зохицуулалтыг сайжруулах, төсвийн хөрөнгө оруулалтын хүрээнд эдгээрийг давхардалгүй, харилцан уялдаатай, үр ашигтай, оновчтой төлөвлөж, хуваарилах, ач холбогдлын эрэмбэ, үнэлгээнд үндэслэдэг байх, шаардлагагүй тохиолдолд зээлийн хөрөнгө оруулалт авахгүй байх, төсөл, арга хэмжээг үр ашигтай, үр дүнтэй хэрэгжүүлэхэд төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн байгууллагууд болон бусад оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, санхүүжилт, зарцуулалт, бүртгэл, тайлагналт, ил тод байдлыг сайжруулахад чиглэсэн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага бий болсон.

Дээр дурдсан хууль зүйн үндэслэл, практик шаардлагад тулгуурлан Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төслийг боловсруулна. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлд заасан хууль санаачлах эрхийн хүрээ, хязгаарт нийцнэ.

Хоёр.Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн зорилго нь хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд нийгэм, эдийн засгийн дэд бүтцийг бүрдүүлэхэд төсвийн хөрөнгө оруулалтын төслийн төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт, хөрөнгийн удирдлага, ашиглалтыг ил тод, үр ашигтай хэрэгжүүлэхтэй холбогдуулан төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын эрх зүйн нэгдмэл орчныг бүрдүүлэхэд оршино.

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан анхдагч хуулийн төсөл хэлбэрээр боловсруулна. Хуулийн төсөл нь 8 бүлэгтэй байх бөгөөд доор дурдсан харилцааг зохицуулна. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт нийтлэг үндэслэлийг тодорхойлох энэхүү бүлэгт хуулийн зорилго, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын хууль тогтоомж, үйлчлэх хүрээ, хуулийн нэр томъёоны тодорхойлолт, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагад баримтлах зарчим, төсвийн хөрөнгө оруулалтын төслийн ангилал, төрөл, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цаглавар болон төсвийн хөрөнгө оруулалтад хориглох зүйл зэргийг тусгана.

Хоёрдугаар бүлэгт төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын талаарх төрийн байгууллагын бүрэн эрх, чиг үүргийн талаарх уг бүлэгт Засгийн газар, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн эрхэлсэн Засгийн газрын гишүүн, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга болон захиалагчийн төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын талаарх бүрэн эрх, чиг үүргийг тусгана.

Гуравдугаар бүлэгт төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, төслийн үнэлгээ, тавигдах шаардлагын хүрээнд төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, тэргүүлэх салбар, хөрөнгийн эх үүсвэрийн зориулалт, төлөвлөлтийн үйл ажиллагаа буюу

төслийг төлөвлөх, бэлтгэх үе шат, төслүүдийн нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийг тооцох, үнэлэх, эрэмбэлэх шалгуур үзүүлэлт, тавигдах шаардлага зэргийг тодорхойлж, төлөвлөлтөд их өгөгдөл, хиймэл оюун ухаан, цахим систем ашиглах зэргийг журмаар бус уг хуулийн төсөлд зохицуулалтыг тусгана. Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн ангиллыг шинээр тодорхойлсны дагуу улсын төсөв, орон нутгийн төсөв болон гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг ялгамжтай тогтоох бөгөөд төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг оновчтой, үр өгөөжтэй зарцуулах боломж бүрдэнэ.

Дөрөвдүгээр бүлэгт төсвийн хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналтын талаар эрх шилжүүлэх асуудал, хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилт, худалдан авах ажиллагаа, гэрээний удирдлага, гүйцэтгэлийн санхүүжилт, төслийн санхүүжих дүнд хийх хөрөнгийн зохицуулалтын талаар тусгаж, төслийн гүйцэтгэлд тавих хяналт, захиалагчийн техникийн болон зохиогчийн хяналтын тухай авч үзэхээс гадна төслийн хэрэгжилтийн тайлагналт, үр дүнгийн талаар төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр тус бүрээр зохицуулна. Тодруулбал, улсын төсөв, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, гадаад зээл, тусламж болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн төсөвт ногдох хэсэгт хамаарах харилцааг тусгана. Төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой журмаар зохицуулж байгаа харилцааг хуульд тусгана.

Тавдугаар бүлэгт төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын ил тод, нээлттэй байдал, цахим системийн удирдлагын зохицуулалтын хүрээнд төсвийн хөрөнгө оруулалтын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, удирдах талаар тусгахаас гадна төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системийн удирдлагыг хэрэгжүүлэх, олон нийтийн оролцоо, ил тод байдлыг хангах зэрэг асуудлыг тусгана.

Зургаадугаар бүлэгт хөрөнгийн удирдлага, ашиглалт, түүний үр өгөөжийн талаар нийтийн өмчийн эрх зүйн шинэчлэлтэй уялдуулан нийтийн буюу төрийн болон орон нутгийн өмчид бүртгэх, өмч, хөрөнгийн ашиглалт, сайжруулалт, тэдгээрийн үр өгөөжийг тооцож, хөрөнгийн үнэлгээ хийж, төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон өмч, хөрөнгийн удирдлагыг сайжруулах, үр өгөөжтэй, оновчтой зохицуулалтыг бүрдүүлнэ.

Долоодугаар бүлэгт төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын сан буюу норм, нормативын сангийн удирдлага, сангийн эх үүсвэр болон зарцуулалт, тайлагналт, ил тод байдлын талаар журмаар бус уг хуулийн төсөлд тусгах бөгөөд мөн төсвийн хөрөнгө оруулалтын төслийн гүйцэтгэгчийг үнэлэх талаар авч үзнэ.

Наймдугаар бүлэг бусад зүйлд төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын явцад үүссэн маргааныг шийдвэрлэх, хохирол, гэм хорыг нөхөн төлүүлэх, хууль тогтоомж, гэрээний үүргийн зөрчилд хариуцлага хүлээлгэх үндэслэл, хууль хүчин төгөлдөр болох талаарх зохицуулалтыг тусгана.

Гурав.Хууль батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төсөл батлагдсанаар нийгэм, эдийн засагт сөрөг үр дагавар гарахгүй бөгөөд төсвийн хөрөнгө оруулалтын

удирдлагын оновчтой, зөв бодлогыг тодорхойлж, улсын болон бүс нутгийн хөгжилд зориулсан төсөл, хөтөлбөрүүдийг үр дүнтэй, амжилттай хэрэгжүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, дэд бүтцийн болон нийгмийн хөгжлийг эрчимжүүлж, төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад төсвийн хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйн нэгдмэл, цогц, таатай орчныг бүрдүүлэх томоохон ач холбогдолтой юм.

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төслийг баталснаар батлан хэрэгжүүлснээр дараах ач холбогдол, эерэг үр дагаврыг бий болгоно. Үүнд:

1.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын олон улсын жишигт нийцсэн, хууль, эрх зүйн нэгдмэл орчин бүрдэж, санхүүжилтийн эх үүсвэрийн оновчтой хуваарилалт, зохицуулалтын дагуу хөрөнгө оруулалтын эдийн засгийн үр ашиг дээшилж, нийгмийн ач холбогдол сайжирна;

2.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн ангилал, төрөл, тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт тодорхой болсноор төсөл амжилттай хэрэгжих хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдэхээс гадна улс, бүс, орон нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжинэ;

3.Төслийн бэлтгэл үе шатны үндсэн асуудал болох газар, зураг төсөл, төсөв, ТЭЗҮ-д хамаарах зохицуулалтыг бий болгосноор төслийн нийт өртөг, цар хүрээ, онцлог зэргээс хамаарч ялгамжтай, үр дүнтэй хэрэгжих боломж бүрдэнэ;

4.Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналт, өмчийн удирдлага, ашиглалт зэрэг харилцааг бүрэн зохицуулж, түүнд их өгөгдөл, хиймэл оюун ухаан, цахим системийн удирдлагыг хэрэгжүүлснээр төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжтэй, нээлттэй, ил тод байх зарчим хангагдана;

5.Төслийн нийт зардал буюу барилга байгууламж, тоног төхөөрөмж, ашиглалтын зардал зэргийг хамт тооцон төлөвлөснөөр төсвийн хөрөнгө оруулалтыг хэмнэлттэй, үр ашигтай хэрэгжүүлэх зарчим хангагдана;

6.Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд жендэрийн мэдрэмжтэй, эрчим хүчний хэмнэлттэй, ногоон хөрөнгө оруулалтыг бий болгосноор ашиглалтын буюу урсгал зардлыг бууруулах боломж бүрдэнэ;

7.Төсөл хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын хувь хэмжээ, зохицуулалтыг тодорхой болгосноор зардлын хэтрэлт үүсэхээс сэргийлж, нэмэлт төсөв, санхүүжилт шаардахгүй байх нөхцөл бүрдэнэ;

8.Төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд оролцогч этгээдийн эрх, үүрэг, хариуцлага, хяналтыг сайжруулснаар төсөл амжилттай, үр дүнтэй хэрэгжих боломж бүрдэнэ;

9.Төсвийн хөрөнгө оруулалтын үндэсний мэдээллийн сан бүрдүүлж, төсвийн хөрөнгө оруулалтад их өгөгдөл, хиймэл оюуныг нэвтрүүлснээр хэрэгцээ шаардлагыг хангасан, хөгжлийг дэмжсэн оновчтой төслийг хэрэгжүүлнэ;

10.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын харилцааг олон тооны журам, аргачлалаар зохицуулж байгааг цэгцлэн хуулиар зохицуулснаар нэгдмэл, цогц хууль,

эрх зүйн орчин бүрдэж, хууль тогтоомж дахь хийдэл арилж, төсвийн хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйн зохицуулалт эрэмбийн хувьд илүү сайжирна;

11.Төсвийн холбогдолтой хууль тогтоомж дахь зарчмууд, хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан зорилтууд болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөл, Үндэсний аудитын газар, олон улсын байгууллагуудын санал, зөвлөмжүүд хэрэгжих боломжтой болно;

12.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын хүрээнд практикт тулгамдаж буй нэн чухал асуудлууд шийдвэрлэгдэх боломж бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна.

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүгийн хуульд нэмэлт оруулах тухай болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай,Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай тус тус хуулийн төсөл болон Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулна.

----o0o----